



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/40

Шивээговь сум

Хяналт шалгалтын ажил зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ.НЬ:

1.Төрөөс баримталж байгаа хүнсний эрүүл ахуйн чиглэлээр сумын хэмжээнд хяналт шалгалтын ажлыг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Гантуяа

(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Г.Дашдэлэг

(Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)

Б.Алтансүх

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

А.Азбаяр

(Цагдаагийн хэсгийн жижүүрийн цагдаа)

Нарийн бичгийн дарга:

Д.Амартүвшин

(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

3.Хяналт шалгалтын ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4.Ажлыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, үр дүнг дүгнэн зохих арга хэмжээг авч ажиллан тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (М.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны

03 сарын 06 өдрийн

А/40 дугаар захирамжийн хавсралт



Хяналт шалгалтын ажил зохион байгуулах ажлын удирдамж

Нэг. Зорилго

Сумын хүнсний худалдаа эрхэлж байгаа аж ахуй нэгж албан байгуулагад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, анхааруулга сэрэмжлүүлэг зөвлөгөө өгч ажиллахад оршино.

Хоёр. Хугацаа

Хяналт шалгалтын ажлыг 2024 оны 03 дүгээр сарын 11-ний өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэх.

Гурав. Илэрсэн зөрчлийг шийдвэрлэх

Хяналт шалгалтаар илэрсэн хууль бус үйлдлийг таслан зогсоож, холбогдох байгууллагад шилжүүлэн хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллана.

Дөрөв. Зохион байгуулагдах ажил

- Хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, стандартын хүрээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах
- Хүнсний аюулгүй байдалыг хангаагүй бүтээгдэхүүн үйлчилгээг хураах, устгах арга хэмжээ авч ажиллах
- Хүнсний худалдаа эрхлэгчдийн худалдан борлуулж байгаа хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг хянаж шалгах
- Бүтээгдэхүүний хадгалалт, агуулахын шаардлага хангасан байдалд хяналт шалгалт хийх
- Хүнсний худалдаа үйлчилгээтэй холбоотой баримт бичгийн бүрдлийг шалгах